МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.21 № 01/24

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАДАМСҮРЭН ТАНАА

Төсвийн орлого болгох тухай

Хан-Уул дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 2012 оны санхүүгийн тайланд 588.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.Үүнд:

2012 оны 12 дугаар сарын 18-нд принтерийн хорны үнэнд 438,2 мянга, шагнал болон шатахууны зардалд 150,0 мянга, нийт 588,2 мянган төгрөгийг халамжийн сангаас зарцуулсан нь “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно... гэж заасныг зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Улсын төсөвт төвлөрүүлэх 588,2 мянган төгрөгийг Үндэсний Аудитын газрын Төрийн сангийн 900000601 тоот дансанд 2013 оны 4 дугаар сарын 5-ны, дотор төвлөрүүлэх
2. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2012 оны 4 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хан-Уул дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга Б.Бадамсүрэн, ерөнхий нягтлан бодогч Х.Оюунбилэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
Үндэсний аудитын газрын
Аудитор Ш.Оттонбаяр

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:
Хан-Уул дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Бадамсүрэн

Ерөнхий нягтлан бодогч Х.Оюунбилэг

070071